



Funded by
the European Union



Akademie



MEDIA
COUNCIL OF
MONGOLIA



МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

**“Өөрчлөлтийн дуу
хоолой: Иргэний
нийгмийн байгууллагууд
эгэх хариуцлага, ил тод
байдал, олон нийтийн
ойлголтын төлөө хүчээ
нэгтгэх нь” төсөл,
2023-2026**

Улаанбаатар хот
2025 он

Холбоо барих мэдээлэл:

Монгол Улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 43-р
хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж,
Юу Би тауэр, 10-р давхар, #1004

Утас: (976) 7000 0180

И-мэйл: info@mediacouncil.mn

Вэбсайт: www.mediacouncil.mn

Facebook: V4C - Өөрчлөлтийн дуу хоолой

Instagram: v4c_official

ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУД ЭГЭХ ХАРИУЦЛАГЫН ЗАРЧМУУДАА ТАНИЛЦУУЛЛАА

Иргэний нийгмийн байгууллагуудын эгэх хариуцлагыг бэхжүүлэх зорилготой "Хөгжлийн төлөөх хариуцлага: Иргэний нийгмийн санаачилга" баримт бичгийг төслийн оролцогч талууд хамтран боловсруулж хэлэлцэн баталлаа. Хариуцлагатай иргэний нийгэм чанарын удирдлагыг манлайлан хэрэгжүүлэхээр зорьж буй 18 иргэний нийгмийн байгууллага хүний эрхийг дэмжих, хараат бусаар ажиллах, шийдвэр гаргах үйл явцад оролцоог нэмэгдүүлэх зэрэг 9 үндсэн зарчим бүхий энэхүү баримт бичигт гарын үсэг зуран нэгдэв. Эдгээр зарчим нь иргэний нийгмийн талаарх иргэдийн итгэлийг нэмэгдүүлж,

тогтвортой хөгжлийн зорилтуудад хувь нэмэр оруулж, бодлогын өөрчлөлтөд үр дүнтэй нөлөөлөх боломжийг бүрдүүлэхэд чиглэж буй.

Цаашид иргэний нийгмийн эгэх хариуцлагыг бэхүүлэхэд чиглэсэн эдгээр зарчим нь улам төгөлдөржиж, иргэний нийгмийн нэр хүнд, итгэлийг бэхжүүлэн утга учиртай өөрчлөлтийг авчирна хэмээн ХМЗ-ийн гүйцэтгэх захирал Г.Гүнжидмаа уулзалтын үеэр онцлов.

2023 оны нэгдүгээр сараас өнөөг хүртэл хамтран ажиллаж иргэний нийгмийг бэхжүүлж, утга учиртай өөрчлөлтийг авчрахын төлөө "Хөгжлийн төлөөх хариуцлага: Иргэний нийгмийн санаачилга" эгэх



хариуцлагын зарчмуудыг боловсруулж, өлгийдөн авсан бүх оролцогч байгууллагадаа талархал илэрхийлье!

Бүрэн эхээр нь үзэх:

<https://www.mediacouncil.mn/a/679>



СУРГАЛТЫН СОНИН САЙХНААС

Сайн засаглалд хөтлөх “Алтангадас” аргачлалд суралцаж байна

Хариуцлагатай иргэний нийгэм чанарын удирдлагыг нэвтрүүлэхээр зорьж буй 15 иргэний нийгмийн байгууллагын урт хугацааны тогтвортой байдлыг дэмжих, сайн засаглал, ил тод, олон нийтэд ойлгомжтой хүртээмжтэй байдлыг дэмжих нь “Өөрчлөлтийн дуу хоолой” төслийн чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Энэ хүрээнд Сэтгүүл зүйн Инновац, Хөгжлийн Үүр төвтэй хамтран ИНБ-уудад зориулсан урт хугацааны сургалт, зөвлөх менторшип

хөтөлбөрийг эхлүүлээ. Дөрөвдүгээр сарын 23-25-ны өдрүүдэд иргэний нийгмийн байгууллагын урт хугацааны стратеги тодорхойлох “Алтангадас” сургалтыг тус төвөөс амжилттай зохион байгуулж 11 байгууллагын 20 гаруй төлөөллийг хамрууллаа. Сургалтад хамрагдсан байгууллагууд ирэх гурваас таван жилийн зорилго, зорилтуудаа нарийвчлан тодорхойлохоос эхлээд өдөр тутмын үйл ажиллагааны төлөвлөгөөгөө гаргасан юм.

Сургалтад бүрэн хамрагдсан цаашид менторшип хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй зургаан иргэний нийгмийн байгууллагыг сонгон урт хугацааны зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр болов.




НЯГТЛАН ШАЛГАХ АРГА ЗҮЙД СУРАЛЦАВ

Иргэний нийгмийнхэнд зориулсан “Баримт нягтлан шалгах арга зүй” сургалтыг тавдугаар сарын 7, 28-нд цахимаар болон танхимаар тус тус зохион байгууллаа. Сургалтад иргэний нийгмийг

төлөөлөх 30 орчим байгууллагын 40 гаруй төлөөлөгч хамрагдаж, мэдлэг туршлагаасаа хуваалцав. Тэд мэдээллийг нягтлан шалгах арга зүйд суралцсанаар хуурамч, ташаа мэдээллээс иргэдийг хамгаалах, төөрөгдүүлсэн, гуйвуулсан мэдээллийг залруулахад бодит хувь нэмэр оруулах, баталгаат мэдээлэлд суурилсан

нөлөөллийн ажлаа үр дүнтэй явуулах зэрэг олон талын ач холбогдолтой.

Сургалтаар худал мэдээллийн төрөл, шалтгаан, баримт шалгах үндсэн зарчмууд, хуурамч мэдээллийг таних хэрэгслүүд, хамтран ажиллах боломжууд, сошиал медиа алгоритм ба мэдээллийн хязгаарлалт зэрэг хэд хэдэн сэдвийг хөндсөн. Оролцогчид онолын мэдлэгээ практикт ашиглан дасгал хийж, харилцан санал солилцож хамтран суралцсан юм.



“Иргэний орон зай ба бодлого боловсруулалт” зөвлөлдөх уулзалт болов

2025 оны дөрөвдүгээр сарын 10-нд Хэвлэл Мэдээллийн Зөвлөлөөс ИНБ-уудад хамаарал бүхий эрх зүйн зохицуулалт болох Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл тэдгээрт хамаарал бүхий эрх зүйн судалгааны талаар иргэний нийгмийн байгууллага, хэвлэл мэдээллийн болон төрийн байгууллагуудыг хамруулсан зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа. Монгол Улсын Засгийн Газар 2017 оноос хойш удаа дараа ИНБ-д хамаарах эрх зүйн зохицуулалтыг боловсруулж ирсэн. Тэр дундаа 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр УИХ-д Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл, Холбооны эрх зүйн байдлын тухай шинэчилсэн хуулийн төслийг өргөн барьсан. Уг хуулийн төслүүд нь 1997 онд батлагдан одоо хүчин төгөлдөр мөрдөж буй Төрийн бус байгууллагын тухай хуулийн хэрэгжилт, тулгарч буй бэрхшээлтэй асуудал,



түүний цар хүрээг тодорхойлон Монгол Улсад төрийн бус байгууллагуудын (ТББ) үүсгэн байгуулалт, үйл ажиллагааг зохицуулах зорилготой. Уг хуулийн төсөлтэй холбогдуулан ТББ-ууд, тэдгээрийн эвсэл, консорциум, ашгийн төлөө бус олон улсын байгууллага зэргээс эвлэлдэн нэгдэх эрх чөлөөтэй холбоотой зохицуулалтын хязгаарлалт, зүйл заалтын тодорхой бус байдлыг удаа дараа илэрхийлж иржээ. Тус

уулзалт нь иргэний нийгмийн байгууллагын эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхтэй холбогдуулан оролцогч талуудын мэдлэг, ойлголтыг нэгтгэхийн сацуугаар ИНБ болон хэвлэл мэдээллийн байгууллагын цаашдын үүрэг оролцоог тодорхойлоход чиглэгдэж буйгаараа онцлог юм. Зөвлөлдөх уулзалтад Монголын Залуучуудын Эвсэл ТББ-ын Ерөнхий захирал Т.Амарзаяа, Оюуны

инноваци ТББ-ын Гүйцэтгэх захирал Б.Төрболд нар илтгэл хэлэлцүүлэн, иргэний нийгмийн тухай бодлого боловсруулалт ба судалгааны үр нөлөөний талаар зөвлөлдлөө. ХЗДХЯ, ХЭҮК зэрэг төрийн байгууллагууд, мөн иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагуудын төлөөлөл болох 20 гаруй хүн оролцож санал солилцлоо.

Сэтгүүл зүйн хамтын бүтээлүүд

“Өөрчлөлтийн дуу хоолой” төслийн нэг чухал зорилго нь иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн хамтын ажиллагааг дэмжих явдал юм. Энэ хүрээнд өнгөрсөн арванхоёрдугаар сард иргэний нийгмийн төлөөлөгчид болон сэтгүүлчдийг хамруулан тодорхой асуудал, сэдвийн талаар санал солилцох **“СЭДВИЙН САНАЛ УРАЛДУУЛАХ/ХЭЛЭЛЦЭХ”** уулзалтыг амжилттай зохион байгуулсан. Уг уулзалтаар хэлэлцсэн зарим чухал сэдэв, асуудлыг олон нийтэд хүргэх зорилгоор оролцогч талууд хамтран ажиллаж, сэтгүүл зүйн бүтээлүүдийг бэлтгэн толилуулж байна. Иргэний нийгмийн байгууллага, сэтгүүлчдийн хамтран ажиллаж уншигч, үзэгчдэд хүргэсэн бүтээлүүдтэй танилцана уу:

СУРВАЛЖИЛГА: Таны амьдралд хамгийн их хэрэг болдог гар утасны аппликейшн юу вэ?

Сэтгүүлч: Г.Тэгшсүрэн

“Хөгжлийн туслалцаа төв” ТББ, Ч.Дэлгэрмаа

Эх сурвалж: <https://gogo.mn/r/j6q78> (gogo.mn)

Хүнийг эмчлэх гээд хүлж номхтгож буйг НҮБ эрүүдэн шүүлт гэж үзжээ

Сэтгүүлч: Г.Тэгшсүрэн

“Сэтгэлзүйн мэдрэмж” ТББ, доктор Ү.Сэмжидмаа

Эх сурвалж: <https://shorturl.at/45gN4> (gogo.mn)

Тэгш хамруулах бодлого хөдөөд ч амилж байна

Сэтгүүлч: Х.Болормаа

Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг,

Б.Саранцэцэг

Эх сурвалж: <https://shorturl.at/ngqb4> (time.mn)

Зэрлэг нохойд хөөгдөж яваад, хөлөө хугалсан

гөрөөсөнд Б.Сансар мэс засал хийжээ

Сэтгүүлч: Х.Болормаа

Монголын байгаль хамгаалагчдын холбоо,

С.Баярхүү

Эх сурвалж: <https://shorturl.at/Ej3TI> (time.mn)

Ашиггүй ажилласан төрийн өмчит компанийн захирлууд ₮900 саяын урамшуулал авсан байдаг

Сэтгүүлч: Б.Алтанхуяг

Захиргааны шинэ санаачилга ТББ, С.Цэрэнпүрэв

Эх сурвалж: <https://tinyurl.com/yckc42et> (NTV

телевиз)

Сургуулийн захирал сурагчидтай мэндлэх гэх мэтийн менежментийг 1.2 тэрбум төгрөгөөр зарим сургуульд хэрэгжүүлж байна. Мөн ашиг сонирхлын зөрчилтэй этгээдийн дансанд мөнгийг шилжүүлжээ

Сэтгүүлч: Б.Батцэцэг, [Newsroom.mn](https://newsroom.mn)

Боловсрол эвсэл ТББ, Б.Батчимэг

Эх сурвалж: <https://shorturl.at/KsETq> (newsroom.mn)

Цахим шошго хүүхдийн насан туршийн хоригт орж байна

Сэтгүүлч: Ч.Нямдаваа

Хөөрхөн зүрх ТББ, Кристина Нобелийн сан ТББ,

Ч.Очгэрэл

Эх сурвалж: <https://tinyurl.com/5n7jecth> (24tsag.mn)

Тохиролцохгүй тохироон дээр тоглуулсан эрх

Сэтгүүлч: Я.Хулан

Газрын эзэн баян зүрх нөхөрлөл ТББ, хуульч

Б.Мөнх-Амар

Эх сурвалж: <https://tinyurl.com/25tnnnrcr> (ublfe.mn)

УРИН САЛХИ УТААГ ҮЛЭЭДЭГ Ч ДАЛД АСУУДАЛ ДУУСААГҮЙ БАЙНА

Сэтгүүлч: О.Амарзаяа
ЛЭОС-ийн Архангай аймаг дахь салбарын тэргүүн, Б.Батцэцэг
Эх сурвалж: Архангайн амьдрал сонин

Хүүхдийг дэлгэцээс холдуулах ХҮЧ, эцэг эхийн ОРОЛЦООНД бий

Сэтгүүлч: П.Энхмаа
ЛЭОС-гийн Увс аймаг дахь салбарын тэргүүн, Б.Батхүү
Эх сурвалж: <https://tinyurl.com/bdcmufp9> (uvschuud.mn)

ЮНЕСКО морин уралдааныг бүртгэлээ гээд монгол хүүхдийн амь үнэгүйдэх ёсгүй

Сэтгүүлч: Д.Мягмаржаргал
Орон нутгийн хэвлэл мэдээллийн холбоо ТББ, Ч.Баярсайхан
Эх сурвалж: <https://tinyurl.com/5y9p3znr> (unuudur.mn)

“Арьс ширний 80” айлын асуудалд анхаарал хэн хандуулах вэ?

Сэтгүүлч: Б.Нямсүрэн
Газрын эзэн баян зүрх нөхөрлөл, Б.Нямжав
Эх сурвалж: <https://www.zms.mn/a/101864> (Зууны мэдээ сонин)

Төр айлгадаг хэрэгсэл байж болохгүй

Сэтгүүлч: Б.Нямсүрэн
Газрын эзэн баян зүрх нөхөрлөл, Б.Нямжав
Эх сурвалж: <https://www.zms.mn/a/102042> (Зууны мэдээ сонин)

Иргэний нийгмийн байгууллагуудын “сайн жишиг” тогтоож буй хайр татам, онцлох 10 ажил

Сэтгүүлч: О.Анхзаяа
Эх сурвалж: <https://ub.life/p/250725-6q8rpi> (ub.life)

Зүрх сэтгэлийн боловсролыг орон нутагт

Сэтгүүлч: Б.Лхагвацэрэн
Иргэний засаглал ТББ, Б.Ууганхүү
Эх сурвалж: <https://tinyurl.com/yryvm6z9w> (unnu.news)

Хар дарсан зүүд шиг- хүүхдийн цахим мөлжлөгийн түүх

Сэтгүүлч: Д.Болорчимэг
Эерэг өөрчлөлт нэмэх ТББ, Д.Гүнжилмаа
Эх сурвалж: <https://shorturl.at/z1hh7> (peak.mn)

Бидний ихэнх нь сонгуулийн үйл ажиллагааг 4 жил тутамд нэг удаа зохион байгуулагдаад дуусдаг гэж ойлгодог ч жил бүр нөхөн сонгууль явагддаг гэдгийг та мэдэх үү?

Сэтгүүлч: Ц.Цэрэндолгор
Сонгогчдын боловсрол төв, С.Оюунтуяа
Эх сурвалж: <https://tinyurl.com/yn77mfvr> (peak.mn)

Тахарын албыг сэргээж, гэрч хохирогчдын амь, эрүүл мэндийг хамгаалъя

Сэтгүүлч: Г.Өлзийбат
Legal Media Ч.Өнөржаргал
Эх сурвалж: <https://tinyurl.com/45sxtjp4> (live24.mn)

Гэр бүл цуцлуулах өргөдөл өгсөн үед хүчирхийлэлд өртөх, амь насаа алдах эрсдэл 2-3 дахин нэмэгддэг

Сэтгүүлч: NTV Телевиз
Эх сурвалж: <https://www.youtube.com/watch?v=uNoizskYZeM>

СХД-ийн 26-р хорооны Өрхийн эрүүл мэндийн төв явуулын баг ажиллуулан, хүүхдүүдийг улаанбурханы ...

Сэтгүүлч: NTV Телевиз
Эх сурвалж: <https://www.youtube.com/watch?v=MbuXYZLNYD8&t=60s>

Айдастай хотод амгалан алхах эрхгүй болж байна

Сэтгүүлч: Ө.Билэгт
Эх сурвалж: <https://tinyurl.com/mjfcy7m6> (urug.mn)

Нарансэвстэйн боомтын цаадах халхлагдсан үнэн

Сэтгүүлч: Ц.Эрдэнэтуяа,
Байгал орчны иргэний зөвлөл Ч.Дулмаа
Эх сурвалж: <https://tinyurl.com/mtv94fmy> (niitlel.mn)

Хэрэгждэггүй дахин төлөвлөлтөөс болж иргэд халаалтгүй, усгүй, цахилгаангүй балгас шиг байранд амьдарч байна

Сэтгүүлч: А.Баярмаа
Газрын эзэн баян зүрх нөхөрлөл, Б.Нямжав
Эх сурвалж: <https://www.tac.mn/article/149818> (tac.mn)

Сошиал нөлөөлөгчдийн үйлдэл хүүхдүүдэд инээд биш ханиад болж байна

Сэтгүүлч: З.Энхзул
Дорнын манлайлал ТББ, Г.Гантуул
Эх сурвалж: <https://shorturl.at/RywiV> (Дорноговь телевиз DTV's social page)

Төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагуудын гурван талт уулзалтууд боллоо

Хэвлэл мэдээллийн зөвлөлөөс санаачлан төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг нэмэгдүүлэхэд чиглэсэн гурван талт уулзалт, хэлэлцүүлгийг 6-р сарын 10-нд Өвөрхангай аймагт, 6-р сарын 27-нд Дорноговь аймагт тус тус зохион байгууллаа.

Өвөрхангай аймгийн Арвайхээр хотноо болсон “Төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагуудын хамтын ажиллагаа, харилцан ойлголцол” сэдвээр хэлэлцүүлэгт төр, ИНБ, хэвлэл мэдээллийн төлөөлөл оролцож, ил тод байдал, иргэдийн оролцоо, хамтын ажиллагааны талаар санал солилцсон юм. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг “Бүтээлч гар” ТББ-ын үйл ажиллагаатай танилцаж, хэвлэл мэдээлэл-иргэний нийгмийн хамтын ажиллагааны үр нөлөөг хэлэлцэв. Түүнчлэн сэтгүүлчид салбарын сорилт, ёс зүй, төр болон ИНБ-уудтай харилцах боломжийн талаар ярилцлаа.

Дорноговь аймгийн Сайншанд хотноо болсон “Төр, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагуудын харилцан ойлголцол, түншлэл” хэлэлцүүлгээр мэдээллийн ил тод байдал, эгэх хариуцлага, оролцогч талуудын харилцаа холбоо, түншлэлийн ач холбогдлыг онцлон, ардчилсан

нийгэм дэх иргэний нийгэм ба сэтгүүл зүйн оролцооны талаар илтгэл танилцуулж, санал солилцлоо. Хэлэлцүүлэгт Дорноговь аймгийн ИТХ, ЗДТГ, иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ), хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 20 хүн оролцсон. Оролцогчид орон нутагт тулгамдаж буй олон нийтийн мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдал, иргэдийн оролцоо, хариуцлагатай засаглалыг бэхжүүлэх гарцын талаар хэлэлцлээ. Мөн хэвлэл мэдээлэл ба ИНБ-уудын нийгэмд гүйцэтгэх үүргийг онцолж, талуудын хамтын ажиллагааны боломж, тулгамдсан асуудлыг хөндсөн юм.



Иргэний нийгмийн байгууллагын дижитал чадавхийг сайжруулах, бэхжүүлэхэд чиглэсэн 24000 еврогийн санхүүгийн дэмжлэгийг олгохоор боллоо

“Өөрчлөлтийн дуу хоолой” төслийн хүрээнд иргэний нийгмийн байгууллагын дижиталчадавхийг сайжруулах, бэхжүүлэх зорилгоор гуравдагч талуудад санхүүгийн дэмжлэг үзүүлж эхэллээ. Хариуцлагатай иргэний нийгмийн санаачилгад нэгдсэн 15 байгууллагад гуравдугаар сарын 27-нд энэхүү саналыг илгээсэн юм. Тэдгээр байгууллагуудаас 10 нь дижитал чадавхаа сайжруулах хэрэгцээ шаардлага өндөр байгаагаа илэрхийлж төслийн санал ирүүлсэн. Шалгаруулалт маш өрсөлдөөнтэй болсон бөгөөд анх зарлахдаа дурдсан 10 шалгуурын дагуу хоёр байгууллага шалгарч тус бүр 7500 еврогийн санхүүгийн дэмжлэг авахаар болов. Мөн өнөөдрийг хүртлэх төслийн үйл ажиллагаанаас хэмнэсэн үнийн дүнгийн хүрээнд шалгаруулалтын явцад оноогоор 3, 4, 5-рт жагссан гурван байгууллагад тус бүр 3000 еврогийн дэмжлэгийг нэмэлтээр олгохоор боллоо. Шалгарсан байгууллагуудын нэрс болон төслийн тухай мэдээлэл:

Монголын байгаль хамгаалагчдын холбоо

Төслийн нэр: Дижитал байгаль хамгаалагчид: Байгаль хамгааллыг өөрчлөх нь (Digital Rangers: Transforming Conservation)

Дэмжлэгийн дүн: 7500 евро

Хөгжлийн туслалцаа төв

Төслийн нэр: Хүртээмжтэй вебсайт (Accessible website)

Дэмжлэгийн дүн: 7500 евро

МОНФЕМНЕТ Үндэсний сүлжээ

Төслийн нэр: Иргэний нийгмийн байгууллагуудын дижитал ур чадварыг бэхжүүлэх (Digital Literacy Strengthening for Civil Society)

Дэмжлэгийн дүн: 3000 евро

Өгөөмөр мэдээллийн товчоо

Төслийн нэр: Дижитал идэвхтэн (CODE: Community of Digital Enablers)

Дэмжлэгийн дүн: 3000 евро

Хил хязгааргүй алхам төв ТББ

Төслийн нэр: ТББ-ын үйл ажиллагаанд дижитал шийдлүүдийг нэвтрүүлэх (Introducing Digital Solutions in NGO Activities)

Дэмжлэгийн дүн: 3000 евро

Иргэний нийгмийн байгууллагуудын эрх зүйн орчны талаарх судалгаа

Төслийн хоёрдугаар үе шат нь иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээлэл, залуучууд зэрэг нийгмийн олон талт бусад бүлгийг төрийн бодлогын хэлэлцүүлэгт татан оролцуулах, иргэний нийгмийн эрх зүйн таатай орчинг бүрдүүлэхэд чиглэж буй. Энэ хүрээнд Монгол дахь Иргэний нийгмийн байгууллагуудын эрх зүйн

орчны талаарх судалгаа хийх нээлттэй урилгыг дөрөвдүгээр сарын 21-нд зарласан. Эрх зүйн судалгаа хийж зөвлөмж боловсруулахаар зургаан баг саналаа ирүүлсэнээс тодорхой шалгуур, шаардлагын дагуу үнэлгээгээр судлаач Т.Энхжаргал, Т.Амарзаяа болон Д.Тэгшбаяр нарын хоёр баг шалгарлаа.

“Цахим орчинд мэдээлэл түгээхэд баримтлах ёс зүйн гарын авлага”-ыг боловсруулж байна

Төслийн хүрээнд иргэний нийгмийн байгууллагуудын цахим орчинд мэдээлэл түгээхэд баримтлах ёс зүйн гарын авлага боловсруулан танилцуулах гэрээт зөвлөхөөрсэтгүүлч, мэдээлэл харилцааны мэргэжилтэн Ж.Хулан шалгарлаа. “Цахим орчинд мэдээлэл түгээхэд баримтлах ёс зүйн гарын

авлага”-ыг боловсруулах санал солилцох, зөвлөлдөх уулзалтыг 5-р сарын 23-нд хийсэн.

Бодлого боловсруулах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, хакатон, цахим кампанит ажил өрнүүлэх үйл ажиллагаа

Бодлого боловсруулах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, хакатон, цахим кампанит ажил өрнүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх мэргэжилтнүүдийг өргөдөл гаргахыг урьсан. Шалгаруулалт үргэлжилж буй бөгөөд хэрэгжилтийг есдүгээр сараас эхлүүлэхээр төлөвлөж байна.

Үйл ажиллагаа 1: Бодлого боловсруулах түвшинд залуучуудын оролцоог хангах хөтөлбөр боловсруулах сургалт, менторшип

Үйл ажиллагаа 2: Залуучуудын оролцоо, нөлөөллийг нэмэгдүүлэх шийдлийг эрэлхийлэх хакатон

Үйл ажиллагаа 3: Бодлого боловсруулах түвшинд залуучуудын дуу хоолойг хүргэх цахим кампанит ажил



Хэвлэл Мэдээллийн Зөвлөлөөс ХБНГУ-ын Дойче Велле Академи (DWA)-тай хамтран Европын Холбооны дэмжлэгтэйгээр “Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийг 2023-2026 онд хэрэгжүүлж байна. Уг төслийн хүрээнд иргэний нийгмийн байгууллагуудын ил тод, бие даасан байдлыг дэмжиж, иргэний нийгмийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх замаар сайн засаглал, нийгмийн эв нэгдэлд хувь нэмрээ оруулах үндсэн зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Төслийн хоёрдугаар үе шат нь иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээлэл, залуучууд зэрэг нийгмийн олон талт бусад бүлгүүдийг төрийн бодлогын хэлэлцүүлэгт татан оролцуулах эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэж буй юм.

Гурван талт зөвлөлдөх уулзалт боллоо



2025 оны 9 дүгээр сарын 9-нд Хэвлэл Мэдээллийн Зөвлөлөөс Төрийн бус байгууллагын тухай хуулийн хэрэгжилт, өнөөгийн нөхцөл байдал, загвар хуулийн төслийн талаар иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, төрийн байгууллагыг хамарсан гурван талт зөвлөлдөх уулзалтыг зохион байгууллаа.

Уулзалтад Хүний Эрхийн Үндэсний Комисс, Хууль Зүйн Үндэсний Хүрээлэн зэрэг төрийн байгууллагын төлөөллөөс гадна иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагын 20 гаруй төлөөлөгчид оролцов. Судлаач Д.Тэгшбаяр “Төрийн бус байгууллагын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайланг” танилцуулан, “Иргэний нийгмийн байгууллагын тухай хуулийн загвар төсөл”-ийн талаар Монголын Залуучуудын Эвслийн зөвлөх, хуульч Т.Энхжаргал илтгэл хэлэлцүүлэв.

Судалгаанаас зарим мэдээллийг дурдвал “... 28 жилийн хугацаанд 31518 төрийн бус байгууллага үйл ажиллагаагаа эхлүүлсэн бол 2023 оны 7-р сарын сарын 28-

ний өдрийн “Хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасах тухай” УБЕГ-ын даргын А/1345 дугаар тушаалаар 6636 ТББ-г бүртгэлээс хассан байна ...

... Монгол Улсад 2020 онд 22082 ТББ, 2022 оны байдлаар УБЕГ-т нийт 23852 ТББ бүртгэлтэй байсан байна. Харин 2025 оны 7-р сарын 25-ны байдлаар 24882 ТББ бүртгэлтэй байгаагаас 21500 нь нийгэмд үйлчилдэг ТББ, 3382 нь гишүүддээ үйлчилдэг ТББ, 90 олон улсын ТББ-ын салбар, төлөөлөгчийн газар, 1612 сан байна. Ашгийн бус байгууллагад багтах хоршоо 12031, шашны байгууллага 546, боловсролын байгууллага 157, тэдгээрийн 59 нь гадаадын хөрөнгө оруулалттай боловсролын байгууллага байна ...



... Төрийн бус байгууллагын тухай хуулийг 1997 онд баталж, нийт 9 удаа зөвхөн салбарын бусад хууль шинэчлэгдсэнийг дагалдаж нэмэлт өөрчлөлт хийсэн ба ТББ-ын цар хүрээ, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалт, хэлбэр болон санхүүжилт босгох нөхцөл зэрэгт зарчмын томоохон өөрчлөлт хийж байгаагүй ...

... “ашгийн бус байгууллага”-д тусламж, дэмжлэг, төсөл, хөтөлбөрийн санхүүжилтыг зөвхөн тодорхой зорилго, нэг удаагийн төлөвлөлтийн хүрээнд олгож, харин “төрийн бус байгууллага”-д хүний эрхийг хамгаалах, нийгмийн хөгжлийн төлөө тогтмол дэмжлэг үзүүлэн, бүх төрлийн туслалцааг олгодог байна ...” Өөрчлөлтийн дуу хоолой төслийн хүрээнд 2025 оны 4-р сард “Иргэний орон зай ба бодлого боловсруулалт” сэдвээр, мөн 2025 оны 6-р сард “Иргэний нийгмийн санхүүгийн орчин, түүний зохицуулалт ба дэмжлэг” сэдвээр хэлэлцүүлгүүд хийж 40 гаруй төлөөлөлтэй санал солилцсон юм.

Иргэний нийгмийн байгууллагуудын засаглал, ил тод байдлын сургалт болов

“Хөгжлийн төлөөх эгэх хариуцлага: Иргэний нийгмийн санаачилга”-д нэгдсэн 15 ИНБ-уудаас долоо нь байгууллагынхаа засаглал, ил тод байдал, эгэх хариуцлагыг сайжруулах урт хугацааны менторшип хөтөлбөрт хамрагдаж байна. Сэтгүүл зүйн хөгжлийн үүр төвөөс “Өөрчлөлтийн дуу хоолой” төслийн хүрээнд иргэний нийгмийн

байгууллагуудад зориулсан зөвлөх үйлчилгээ, менторшип хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. ИНБ-ын засаглал ба ил тод байдлын ээлжит сургалтад 2025 оны 9-р сарын 17–18-нд онлайнаар (Zoom) долоон иргэний нийгмийн байгууллага хамрагдлаа.

Сургалтаар ТББ-ын засаглалын тогтолцоо, ТУЗ-ийн үүрэг хариуцлага, санхүүгийн хариуцлага, ашиг сонирхлын зөрчлийн менежмент, ил тод байдал, ёс зүйн хэм хэмжээ, гомдол хянан шийдвэрлэх механизм, аудитын сайн туршлага гэсэн гол сэдвүүдийг хамарсан бөгөөд хариуцлагатай, стратегийн

чиг баримжаатай, сайн засаглалтай иргэний нийгмийн байгууллагуудыг хөгжүүлэхэд анхаарлаа.

Сургалтын үеэр бүлгийн дүн шинжилгээ, кейс судалгаа, практик дасгал, харилцан суралцах арга зүй, мэдлэгийн сорил зэрэг интерактив аргуудыг ашиглав. Эдгээр үйл ажиллагаанууд нийлээд ИНБ-уудын стратегийн өсөлт, байгууллагын тогтвортой байдлыг дэмжих цогц менторшип хөтөлбөр болж, илүү хүчирхэг, хариуцлагатай иргэний нийгмийн институцүүдийг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулж байна. Уг үйл ажиллагаа төслийн гурав дахь жилд үргэлжлэн хэрэгжинэ.



Оюутны баримт нягтлан шалгах, хэвлэл мэдээллийн суурь боловсролын (MIL) клубууд байгуулагдлаа

Монгол Улсын Боловсролын Их Сургууль болон Отгонтэнгэр Их Сургууль дээр оюутны баримт нягтлан шалгах, хэвлэл мэдээллийн суурь боловсролын (MIL) клубуудыг амжилттай байгууллаа. Шинээр байгуулагдсан клубуудын үйл ажиллагааг үр дүнтэй эхлүүлэх, оюутнуудын хэвлэл мэдээллийн суурь

боловсрол, шүүмжлэлт сэтгэлгээг бэхжүүлэх зорилгоор “Өөрчлөлтийн дуу хоолой” төслийн дэмжлэгтэйгээр Сэтгүүл зүйн хөгжлийн үүр төвөөс 2025 оны 9 дүгээр сарын 26-нд баримт нягтлан шалгах чадавх бэхжүүлэх сургалтыг зохион байгууллаа. Сургалтад хоёр их сургуулийн 60 оюутан идэвхтэй хамрагдав.

Сургалтаар клубын ойлголт, зорилго, ач холбогдлыг таниулах, залуучуудын хэвлэл мэдээллийн суурь боловсролын ур чадварыг бэхжүүлэх, мэдээллийг хариуцлагатайгаар хэрэглэх соёлыг төлөвшүүлэхэд анхаарлаа. Оюутнууд клуб байгуулах үндэс, зохион байгуулалтын зарчим, кампус



дахь оюутны байгууллагын оролцоо, нийгмийн үүрэг, баримт шалгах клубын эрхэм зорилго, худал мэдээлэл, төөрөгдүүлсэн болон ташаа мэдээллийг таних, худал мэдээллийн нийгэмд үзүүлэх сөрөг нөлөө, баримт шалгах арга зүй, дижитал нягтлан шалгах хэрэгслүүдийн талаар суралцав.

Сургалтын үеэр их сургуулиуд болон Сэтгүүл зүйн хөгжлийн үүр төвийн хооронд Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, оюутны баримт нягтлан шалгах клубуудын үйл ажиллагааг албан ёсоор дэмжих, урт хугацаанд тогтвортой хэрэгжүүлэх хамтын ажиллагаагаа баталгаажууллаа. Мөн оюутнууд хамтран клубын удирдлага, зохион байгуулалтын дараагийн алхмууд, үйл ажиллагааны төлөвлөгөө, оюутан-оюутанд чиглэсэн сургалт, мэдлэг хуваалцах санаачилга, үндэсний хэмжээний залуучуудын баримт шалгах хөтөлбөрүүдэд оролцох боломжийн талаар санал солилцож, бодит төлөвлөлт хийсэн нь онцлох үр дүн байв.



СЭТГҮҮЛ ЗҮЙН ЁС ЗҮЙН ФОРУМ 2025




"Сэтгүүл зүйн ёс зүйн форум 2025" буюу JEF-2025 зургаадахь удаагийн форум аравдугаар сарын 10-нд боллоо. Энэ удаагийн форум "Дижитал эрин үеийн ёс зүй: Хиймэл оюуны сорилт ба боломж" сэдвийн хүрээнд зохион байгуулагдаж, дэвшилтэт технологи буюу AI эрчээ авч буй өнөө цагт хэвлэл мэдээллийн салбарынхан хэрхэн илүү хариуцлагатай бөгөөд ёс зүйтэй ажиллах талаар хэлэлцэв.

Форумын нээлтийг хиймэл оюуны тусламжтай хийсэн видеогоор нээснээс гадна хэлэлцүүлгийн явцад оролцогчдын санал сэтгэгдэл, асуултыг шууд дэлгэцээр хүлээн авч хариултыг өгч байсан нь оролцоог нэмэгдүүлэхэд үр өгөөжтэй байлаа. Форумгаар гурван илтгэл танилцуулж, гурван хэлэлцүүлэг өрнүүлэв.

Европын Холбооноос Монгол Улсад суугаа Элчин сайд Ина Марчюлөните хэлсэн үгэндээ "Хиймэл оюун бол бидний туслагч, бас хэрэгсэл" гэдгийг онцлов. Тэрээр "Сошиал медиан хэрэглээ өндөр болсон энэхүү цагт сэтгүүлчид илүү мэргэжлийн, үнэн бодит, баталгаатай мэдээллийг хүргэж ялгарах учиртай. Европын холбоо нь эртнээс хэвлэл мэдээлэл тэр дундаа сэтгүүлчдийг дэмжин ажилласаар ирсэн. Сэтгүүлчид мэргэжлийн өндөр хариуцлагатай байх ёстой. Хэрэв буруу, ташаа мэдээлэл түгээвэл бид та бүхнийг дэмжиж, хамгаалах боломжгүй болно. Зөвхөн Монголд төдийгүй дэлхийн бусад улс орнуудад яг үүн шиг форум, хэлэлцүүлгүүд өрнөсөөр байна. Энэ төрлийн сургалт, форумуудад үнэн зөв мэдээллийг хэрхэн

таних, хэрхэн шүүмжлэлтэй хандаж, эргэцүүлэх вэ зэрэг мэдээллийг хүргэсээр байна. Тиймээс хиймэл оюун ухааныг ашиглахдаа ёс зүйтэй байх дээр санал нэгдэх нь чухал. Хиймэл оюун ухаан бол бидний туслагч байх боломжтой, бидний зорилгоо биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх нэг хэрэгсэл байж болох ч түүнээс улбаатай ташаа мэдээллээр олон нийтийг буруу тийш бүү хөтөлдөг байгаасай. Хиймэл оюун ухаантай өрсөлдөх өрсөлдөгч биш, харин түүнээс илүү байхад анхааран хичээж ажиллах нь чухал. Учир нь бид хиймэл оюуныг удирдан чиглүүлж, ажилдаа ашиглана, тэр бол хэрэгсэл. Тиймээс сэтгүүлчид аливаа асуудалд эргэцүүлэлтэй, шүүмжлэлтэй хандацгаая." хэмээн оролцогчдод хандаж хэлэв.



Германы Дойче Велле Академийн төслийн менежер Килиан Шутце-Алинский видео мэндчилгээ ирүүлсэн бөгөөд тэрээр “... Саяхан би Европын Радио Телевизийн Холбоо (EBU)-ын нэг эшлэлийг уншсан юм л даа, энэ нь Европт болж буй хиймэл оюуны үйл явцыг тун зөв илэрхийлж байна гэж бодсон. Уг эшлэлд ингэж бичсэн байсан: “Бидний хувьд хэвлэл мэдээллийн салбар дахь хиймэл оюун ухааны тухай яриа сониуч байдлаас зайлшгүй хэрэгцээ рүү шилжсэн үе шатанд байна. Та сэтгүүлч, технологич, продюсер, редактор эсвэл менежер хэн ч байсан, хиймэл оюун ухаан бидний ажил, ажлын урсгал, бүр ёс зүйг хүртэл дахин тодорхойлж байна. Тэгвэл бид хэрхэн түрүүлж алхах вэ, хэрхэн бодитой байх вэ, хэрхэн ухаалаг, хариуцлагатай сонголт хийх вэ?” Эдгээр асуулт яг л “Сэтгүүл зүйн ёс зүйн форум”-ын үеэр хэлэлцэх сэдвүүд байх болно гэдэгт итгэлтэй байна ...

... Энэхүү форум энэ асуудлаар харилцан санал бодлоо солилцох, чухал талбар болж үнэтэй хувь нэмэр оруулж байгаад би үнэхээр баяртай

байна. Та бүхэнд ухаарал өгсөн хэлэлцүүлэг, үнэ цэнтэй сургамж, бодитой үрдүнтэй арга хэмжээ байгаасай гэж хүсэж байна. Тус төслийг хамтран хэрэгжүүлж буй Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөлийн хамт олонд онцгой талархал илэрхийлье. Та бүхэнтэй хамтран ажиллах маань үнэхээрийн таатай байдаг. Мөн энэхүү “Өөрчлөлтийн дуу хоолой” төслийг санхүүжүүлж буй Европын Холбоонд чин сэтгэлийн талархал илэрхийлье.” хэмээн мэндчилгээ дэвшүүлснээр форумын үйл ажиллагаа эхэлсэн.



Хэвлэл мэдээллийн зөвлөл нь Ёс зүйн форумыг санаачлагч, зохион байгуулагчийн хувьд өөрийн үндсэн үйл ажиллагаа болох Ёс зүйн хороодын танилцуулга, хэлэлцүүлгээр форумыг эхлүүлсэн юм. Тус зөвлөлийн [Радио, телевиз, сайтын ёс зүйн хороо](#) болон [Сонин, сэтгүүл, сайтын ёс зүйн хороо](#)д Сэтгүүл зүйн бүтээлийн ёс зүйн дүгнэлт, үр нөлөөний талаараа нээлттэй

хэлэлцэж оролцогчдын санал хүсэлтийг хүлээн авав. Ёс зүйн хороод нь салбар бүрийн төлөөллөөс бүрдсэн тус бүр 15 гишүүнтэй бөгөөд улиралд нэг удаа хуралддаг. ХМЗ байгуулагдсан цагаас хойш (2015) 600 гаруй өргөдөл гомдол хүлээн авч, үүнээс 400 орчмыг хэлэлцжээ. ХМЗ-ийн Ёс зүйн хороонд ирсэн сэтгүүл зүйн бүтээлтэй холбоотой гомдлыг ёс зүйн зарчмынхаа хүрээнд хэрхэн хэлэлцэж, шийдвэр гаргадаг талаар, мөн хиймэл оюуны хөгжлийн үед хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын ач холбогдол, анхаарах зүйлийг ярилцав.



Зочин илтгэгчээр Сэтгүүл зүйн инновац хөгжлийн үүр төв НҮТББ-ын үүсгэн байгуулагч Б.Дуламхорлоо [“Сэтгүүл зүй дэх хиймэл оюуны хэрэглээ, сорилт, ёс зүйн асуудлууд”](#) сэдвээр, Эгүнэ Оюун ХХК-ийн Гүйцэтгэх захирал С.Бадрал [“Хиймэл оюуны хөгжил хаа](#)

МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ 2025

“Өөрчлөлтийн дуу хоолой” төсөл

хүрэх вэ?” сэдвээр, Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссын Судалгаа, дүн шинжилгээний хэлтсийн дарга С.Тунгалагтамир цахим

хөгжлийн суурь нөхцөл, цахим технологийн хүний эрхийн эрсдэл, хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн хийдэл ба хэрэгжилт

гэсэн асуудлуудын хүрээнд тус тус сонирхолтой илтгэл танилцууллаа.



“Хиймэл оюуны хэрэглээ, ёс зүй, редакцын бодлого” хэлэлцүүлгээр сэтгүүл зүй нь ардчиллын тулгуур багана болох хэвлэлийн эрх чөлөөний илэрхийлэл. Сэтгүүл зүйн хэвлэл мэдээллийн редакцын үйл ажиллагаанд хиймэл оюуныг ашиглах нь шуурхай байдлыг хангаж, хяналтыг сайжруулах, улмаар давтамжит үйлдлийг хялбарчлах замаар хүний нөөцийн зардлыг хэмнэх зэрэг үр ашигтай боловч мэдээллийг мушгин гуйвуулах, худал ташаа мэдээлэл тархах, технологийн цензур үүсэх зэрэг сөрөг үр дагаврууд байсаар байна. Сэтгүүл зүйд хиймэл оюуныг ашиглахтай холбоотой ёс зүйн хэм хэмжээ, редакцын бодлого, үр дүнтэй зохицуулалтын талаар хэвлэл мэдээллийн салбар бүрийн төлөөлөл хэлэлцэв.

“Хиймэл оюун ба хэвлэл мэдээллийн суурь боловсрол” хэлэлцүүлгээр хиймэл оюун өдөр тутмын хэрэглээнд олон салбарт нэвтрэхийн хэрээр бидний өмнө мэдээллийн нууцлал, өгөгдлийн аюулгүй байдал, хэрэглэгчийн эрх, зохицуулалт, зохиогчийн эрх, хэрэглээний ёс зүй, мэдээллийн чөлөөт урсгал ба цензур гэх мэт олон сорилт тулгарч байна. Хувь хүн, салбар, улсын түвшинд бид юуг анхаарвал зохих вэ? хэвлэл мэдээллийн хэрэглэгчдээ хэрхэн бэлтгэж, тэднийг яаж хамгаалах вэ? зэрэг хүний эрхийн өргөн хүрээний сэдвээр хэлэлцэв.



Иргэний нийгмийн байгууллагын дигитал чадавхийг сайжруулах бичил төслүүд амжилттай хэрэгжиж байна

“Өөрчлөлтийн дуу хоолой” төслийн хүрээнд иргэний нийгмийн байгууллагын дигиталчадавхийг сайжруулах, бэхжүүлэх зорилгоор гуравдагч талуудад санхүүгийн дэмжлэг олгож шалгарсан таван байгууллага төслөө амжилттай хэрэгжүүлж байна. Эдгээр нь “Хөгжлийн төлөөх эгэх хариуцлага: Иргэний нийгмийн санаачилга”-д нэгдэж “Өөрчлөлтийн дуу хоолой” төслийн үр шимийг хүртэгч ИНБ-ууд юм.

Монголын байгаль хамгаалагчдын холбоо: Монгол Улсад байгаль хамгааллын үйл ажиллагааны үр ашгийг сайжруулахын тулд дигитал инновацийг нэвтрүүлэхээр төслийн хүрээнд хийгдэх апп бүтээх ажлыг хийж байна. Уг “Mongol Ranger” апп нь байгаль хамгаалагчдын бүртгэлийг цахим хэлбэрт шилжүүлж, Монголын байгаль хамгаалагчдын харилцаа холбоо, мэдээлэл цуглуулалт, нөөцийн удирдлагыг хялбаршуулах зорилготой. Энэ төсөл нь байгаль хамгаалагчдын үйл ажиллагааны чадамжийг сайжруулж, үр дүнтэй байгаль хамгааллыг дэмжиж, биологийн олон янз байдлыг хамгааллыг бэхжүүлэх зорилготой. Гол нь сумын байгаль хамгаалагчид, идэвхтэн байгаль хамгаалагчдын туршлага, сорилтуудыг хуваалцах боломжийг олгож, байгаль хамгааллын салбарын засаглал, шийдвэр гаргалтад хувь нэмэр оруулна гэж үзэж

байна.

Төслийн нэр: Дигитал байгаль хамгаалагчид: Байгаль хамгааллыг өөрчлөх нь (Digital Rangers: Transforming Conservation) Дэмжлэгийн дүн: 7500 евро

Өгөөмөр мэдээллийн товчоо:

“CODE–Community of Digital Enablers” төсөл нь байгууллагын дигитал чадавх, мэдээллийн харилцаа, эрсдэлийн удирдлагыг сайжруулж, ил тод, хариуцлагатай, итгэл хүлээсэн, нөлөө бүхий иргэний нийгмийн байгууллага болон хөгжихөд чиглэнэ. Төслийн хүрээнд албан ёсны вэбсайт нээн мэдээллийн ил тод байдал, олон нийттэй харилцах сувгийг бэхжүүлэхээр ажиллаж байна. Ингэснээр иргэдийн идэвхтэй оролцоог дэмжсэн, хариуцлагатай, нээлттэй засаглалыг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулах бөгөөд энэхүү зорилго нь “Өөрчлөлтийн дуу хоолой” санаачилгын үндсэн зорилтуудтай бүрэн нийцэж, орон нутгийн ИНБ-уудыг дигитал шилжилтийн манлайлагч болгоход чиглэж байна.

Төслийн нэр: Дигитал идэвхтэн (CODE: Community of Digital Enablers) Дэмжлэгийн дүн: 3000 евро

Хил хязгааргүй алхам төв ТББ

нь 2006 оноос хойш малчдын эрх, нийгмийн оролцоог дэмжих чиглэлээр идэвхтэй ажиллаж байна. Малчдад цахим орчинд хувийн мэдээллээ хамгаалах, санхүүгийн

эрсдэлээс зайлсхийх, хууль эрх зүй, бодлого боловсруулах үйл явцад оролцоход нь туслах дигитал бичиг үсгийн хөтөлбөрийг өргөжүүлэх нь чухал бөгөөд дигитал урчадвар олгох, ТББ-ын ажилтнууд, иргэд, малчдад шаардлагатай дигитал мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх, дигитал шийдлүүдийг өдөр тутмын үйл ажиллагаандаа үе шаттайгаар нэвтрүүлэх, шаардлагатай багаж, технологитой танилцах боломжийг олгохоор ажиллаж байна.

Төслийн нэр: ТББ-ын үйл ажиллагаанд дигитал шийдлүүдийг нэвтрүүлэх (Introducing Digital Solutions in NGO Activities) Дэмжлэгийн дүн: 3000 евро

Хөгжлийн туслалцаа төв:

Хүртээмжтэй вэбсайтын талаар мэдлэг олгох, WCAG стандартыг таниулах сургалтуудыг амжилттай зохион байгуулж байна. Сургалтын үеэр WCAG стандартын үндсэн зорилго болох хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг оролцуулсан хүртээмжтэй, тэгш боломж бүхий вэб орчныг бүрдүүлэхийн ач холбогдол, мөн уг стандарт нь вэб хөгжүүлэгч, дизайнер, контент бүтээгч, байгууллагын харилцаа холбоо, мэдээллийн технологийн ажилтнууд зэрэг өргөн хүрээний хэрэглэгчдэд зориулсан болохыг онцоллоо.

Энэхүү сургалт нь байгууллагууд цахим үйлчилгээгээ илүү



МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ 2025

“Өөрчлөлтийн дуу хоолой” төсөл



хүртээмжтэй болгох, олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Тухайлбал төрийн үйлчилгээ болон хэвлэл мэдээллийн байгууллагууд вэбсайтынхаа хүртээмжийг WCAG стандартын дагуу автомат болон зөвлөхийн тусламжтай шалгаж, өнгөний ялгарал, бичвэрийн ойлгомж, гарчгийн

бүтэц, гарын товчоор удирдах боломжийг нэн тэргүүнд сайжруулах замаар тэгш хүртээмжтэй, хэрэглэгчдэд ээлтэй орчныг бүрдүүлэх боломжтой.

Төслийн нэр: Хүртээмжтэй вебсайт (Accessible website)
Дэмжлэгийн дүн: 7500 евро

МОНФЕМНЕТ **Үндэсний сүлжээ:** Хувийн болон болон

байгууллагын мэдээллийн аюулгүй байдлаа хамгаалах нь юунаас эхэлдэг вэ? гэсэн асуултад хариулт өгөх хоёр өдрийн “Мэдээллийн аюулгүй байдал ба Хиймэл оюун ухааны хэрэглээ” сургалтыг гишүүддээ зориулан зохион байгууллаа. Мэдээллийн аюулгүй байдлаа хамгаалах нь нэг удаагийн сургалт, оролдлогоор биш өдөр тутмын ажил амьдралд дадал болгон хэвшүүлэх шаардлагатайг ойлгож, мэдээллийн аюулгүй байдлаа хамгаалж, хариуцлагатай байх амлалт өглөө.

Төслийн нэр: Иргэний нийгмийн байгууллагуудын дижитал ур чадварыг бэхжүүлэх (Digital Literacy Strengthening for Civil Society)
Дэмжлэгийн дүн: 3000 евро



Төслийн хүрээнд бичил төсөл хүртсэн Монголын байгаль хамгаалагчдын холбооны үйл ажиллагааг олон нийтэд танилцуулах [ВИДЕО танилцуулга](#) бэлтгэв. Монголын байгаль хамгаалагчдын холбоо нь байгаль хамгаалагчдын эрхийг хамгаалж, тэднийг үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлэн ажилладаг ба 2018 онд үүсгэн байгуулагдсан, 1000 гаруй гишүүнтэй, олон улсын Байгаль хамгаалагчдын

холбооны гишүүн байгууллага бөгөөд дараах чиглэлээр үйл ажиллагааг явуулдаг. Үүнд: 1) Байгаль хамгаалагчдыг чадавхижуулах, нийгмийн баталгааг сайжруулах, хууль эрхзүйн зөвлөгөө өгөх, эрх ашгийг нь хамгаалах; 2) Зөвлөлдөх уулзалт, чуулганыг зохион байгуулж, байгаль хамгаалагчдын дуу хоолойг шийдвэр гаргагчид, олон нийтэд хүргэх; 3) БОЯБ-ын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд

хувь нэмрээ оруулах, судалгаа, сурталчилгаа хийх; 4) Байгаль хамгаалагчдын ажлын байрны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, гадаад, дотоодын туршлага судлуулах; 5) Байгаль орчны салбарын хууль эрхзүйг сайжруулах, чадавхийг бэхжүүлэхэд олон талуудтай хамтран ажиллах; 6) Шилдэг байгаль хамгаалагчдыг шалгаруулах, үйл хэргийг нь олон нийтэд алдаршуулах

ЗАЛУУСЫН ДИЖИТАЛ ОРОЛЦОО, МАНЛАЙЛЛЫГ ДЭМЖИХ “ENGAGE & LEARN” СУРГАЛТ АМЖИЛТТАЙ БОЛЛОО

“Engage & Learn” залуус болон тэдэнтэй ажилладаг иргэний нийгмийн байгууллагуудад зориулсан, бодлогын оролцоо,



хүний эрх, дижитал нөлөөллийг хослуулсан хөтөлбөртэй гурван өдрийн интерактив сургалтыг 2025 оны 10-р сарын 17-19-нд амжилттай зохион байгууллаа. Сургалтыг ДБА, ХМЗ-өөс FARO Foundation болон Монголын залуучуудын эвсэлтэй хамтран зохион байгуулсан.

Тус сургалтын агуулга нь залуусыг дижитал орчинд идэвхтэй, хариуцлагатай оролцогч байхыг дэмжихэд чиглэсэн бөгөөд хүний эрх, цахим оролцоо, бодлого боловсруулах үйл явц, манлайлал, нөлөөллийн арга барил зэрэг өргөн хүрээний сэдвийг хамарсан юм.

Сургалтын эхний өдөр залуус хүний эрх, ардчиллын үнэ цэн, мэдээллийн гажуудал, шүүн тунгаах сэтгэлгээ, цахим орчин дахь иргэний оролцооны талаар мэдлэг олж авсан. Мөн

Facebook, Instagram, TikTok зэрэг платформоор дамжуулан нийгэмд эерэг нөлөө үзүүлэх контент, кампанит ажил өрнүүлэх арга барилд суралцав. Үүний зэрэгцээ хиймэл оюуны хэрэглээ, боломж, эрсдэлийн талаар хэлэлцсэн нь оролцогчдын сонирхлыг ихээхэн татсан юм. Хоёр дахь өдөр иргэний боловсрол, эрхээ хамгаалах, нийгмийн шударга ёс, бодлогын асуудал тодорхойлох, бодлого боловсруулах үйл явцад залуус хэрхэн оролцох боломжтой талаар төвлөрлөө.



Оролцоот хэлэлцүүлэг, тоглоом, бодит жишээн дээр суурилсан дасгалууд нь залуусыг бодлогын орон зайд өөрсдийн байр суурийг ойлгож, илэрхийлэхийг дэмжсэн дасгал ажил байв.

Сургалтын сүүлийн өдөр манлайлал, хамтын шийдэл, ёс зүй, үл тэвчих соёл, авлигын эсрэг үнэт зүйлсийн

талаар хэлэлцэж, дижитал технологийг ашиглан шийдвэр гаргах, цахим нөлөөллийн арга хэрэгслийг практикт туршсан юм.

Сургалтыг чиглүүлэгч багш Х.Ариунчимэг, Ц.Чимэддондог нар удирдан явуулж, хүний эрх, иргэний оролцоо, бодлого, дижитал нөлөөллийн чиглэлээр туршлагатай багш, мэргэжилтнүүд Т.Амарзаяа, М.Саруул-Эрдэнэ, Б.Сүхбат, О.Өлзийбуян, Ж.Өнөмөнх нар залууст мэдлэг, туршлагаа хуваалцлаа. Мөн Монголын

Залуучуудын Эвсэл ТББ, Авлигатай тэмцэх газрын соён гэгээрүүлэх албаны төлөөлөл оролцож, бодит туршлага дээр суурилсан сургалт явуулсан нь сургалтын агуулгыг улам баяжуулсан.

“ENGAGE & LEARN” сургалт нь цаашид зохион байгуулагдах хакатон, нөлөөллийн кампанит ажлын бэлтгэл үе шат болж өгсөнөөрөө онцлог байлаа. Сургалтын хүрээнд оролцогчид нийгмийн асуудлыг



тодорхойлох, дижитал шийдэл боловсруулах, багийн хамтын ажиллагаанд суурилсан санаа хөгжүүлэх суурь мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байна. Ийнхүү тус сургалт нь залуусыг зөвхөн мэдлэгтэй байхаас гадна бодит өөрчлөлт хийх санаачлагч, манлайлагч болоход чиглэсэн цогц арга хэмжээ болж өндөрлөлөө.



“HACK THE FUTURE: ШИЙДВЭР ГАРГАХ ТҮВШИНД ЗАЛУУСЫН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ” ХАКАТОН

Залуусын дуу хоолойг дижитал орчинд хүргэх, тэдний оролцоог бодлого, шийдвэр гаргах түвшинд нэмэгдүүлэх зорилготой [“Hack the Future”](#) хакатон 2025 оны 11-р сарын 6–8-нд боллоо. Хакатонд оролцохоор нийт 100 гаруй залуус бүртгүүлснээс 55 залуус

11 багт хуваагдан өрсөлдлөө. Хакатоны өдрүүдээс өмнө 11-р сарын 1, 3 болон 5-нд цахим менторшип уулзалтууд хийж хакатоны зохион байгуулалт, сэдэв, хэрхэн оролцох, хүлээгдэж буй үр дүнгийн талаар мэдээлэл хуваалцав. Энэхүү тэмцээнд залуус

нийгэмд тулгамдаж буй асуудлуудыг технологийн тусламжтайгаар шийдвэрлэх шинэлэг санаануудыг уралдуулж, шүүгчдийн саналаар шилдэгээр шалгарсан [гурван багийн шийдлийг](#) танилцуулж байна.



"ТАВАН МАРАЛ ОД" БАГ

Хүүхдийн эрхийг хамгаалах урьдчилан сэргийлэх хөтөлбөр: Тус баг нь залуучууд, хүүхдийн эрхийн төлөө шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх, нотолгоонд суурилсан урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийг бий болгох зорилготой. Тэдний шийдэл нь нийгмийн хамгийн эмзэг бүлэгт чиглэсэн бодлогын өөрчлөлтийг эрэлхийлж буйгаараа онцлог байв. "Залуучууд болон хүүхдийн эрхийн төлөө шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх, нотолгооны эх сурвалж бүхий урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөр"-ийг бий болгох шийдлээ танилцуулсан. Мөн тэмцээний дараа 2025 оны 12-р сарын 11-

нд залуучууд болон хүүхдийн эрхийн төлөө шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх, нотолгооны эх сурвалж бүхий урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулахад чиглэсэн **Tod Od** төслийн [танилцуулгаа](#) хийлээ.

"TEAM DIVERSE" БАГ

"Chill хэл, Залуусын хэлээр" платформ: Төрийн албан бичгийн хэллэг буюу "Тэдний хэл" болон залуусын өдөр тутмын "Бидний хэл"-ийн хоорондох ялгааг арилгах зорилготой бөгөөд төсвийн зарцуулалт, аудитын дүгнэлт, төрийн худалдан авалт зэрэг мэдээллийг залууст ойлгомжтой Meme болон Reel

хэлбэрт хөрвүүлэн хүргэх "Chill хэл" платформыг санал болголоо. Тэдний шийдэл нь залууст төсвийн ил тод байдлыг хянах боломжийг хамгийн энгийн, сонирхолтой хэлбэрээр олгох юм. Нийслэлийн төсвийн зарлага 2023 онтой харьцуулахад 4.8 дахин өссөн зэрэг чухал мэдээллүүдийг залууст хамгийн ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрээр хүргэхийг зорьж байна. Энэхүү платформ нь 18-34 насны залуусын хамгийн их хэрэглэдэг, сонирхдог Meme болон Reel хэлбэрээр мэдээллийг боловсруулж, "Шилэн дансыг хэрхэн ашиглах" зэрэг заавруудыг ойлгомжтой байдлаар хүргэнэ.

"0xVoice" БАГ

Иргэний технологийн (Civic-tech) цогц платформ: Залуу гарааны бизнес эрхлэгчдэд хууль эрх зүйн орчны мэдээлэл, дэмжлэг үзүүлэхээс гадна УИХ-ын гишүүдийн ажлын гүйцэтгэлийг хянах, мэдээллийг нэгтгэн харуулах, мөн сонгуульд нэр дэвшигчдийн нэгдсэн мэдээллийн санг үүсгэх замаар сонгогчийн боловсролыг дэмжих зэрэг иргэний оролцоог хангахад чиглэсэн цогц функцуудыг агуулсан байна. Тус багийнхан залуусын оролцоог дэмжих, тэднийг хууль эрх зүйн дэмжлэгээр хангах зорилготой иргэний технологийн (civic-tech) цогц платформыг танилцуулсан.

36 цагийн турш зогсолтгүй бодож, сэтгэж, бүтээн хамтдаа "ирээдүйг хакдсан" 11 багийн дэвшүүлсэн санаа, гаргасан шийдэл бүр залуусын оролцоог нэмэгдүүлэх, нийгэмд эерэг өөрчлөлт авчрах үйлсийн чухал хэсэг байлаа. Энэхүү хакатон нь зөвхөн тэмцээн бус, ижил



зорилготой залуус нэгдэж, бие биенээсээ суралцсан, нөхөрлөсөн, туршлага хуримтлуулсан үнэ цэнтэй цаг хугацаа байсан гэдэгт итгэлтэй байна.

Бусад багийн дэвшүүлсэн шийдэл, санаатай товч танилцана уу.

Багийн нэр: 4W

Шийдэл: Coolchat.mn
платформ

Залууст нэрээ нууцлан, аюулгүй орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг бий болгох, нийгмийн идэвхгүй байдлыг бууруулах зорилготой. Ижил асуудалтай хүмүүс нэгдэж, нэрээ нууцлан чат групп үүсгэн хэлэлцүүлэг өрнүүлнэ. Улмаар хэлэлцсэн асуудлаа хиймэл оюуны тусламжтай албан ёсны өргөдөл гомдол болгон боловсруулж petition.

parliament.mn-д илгээх эсвэл сошиал пост хэлбэрээр түгээн нөлөөлөл үзүүлнэ.

Багийн нэр: Brainstorm

Шийдэл: CypMэд платформ 18-25 насны залуучуудын сонгуулийн ирц, улс төрийн оролцоо хангалтгүй байдаг нь ЕБС-аас эхлэн иргэний боловсрол, оролцооны дадал олгодоггүйтэй холбоотой. Ахлах ангийн сурагчдад (16-18 нас) зориулсан, тоглоомын аргачлалтай платформ. Сурагчид сонгууль өгөх, санал асуулгад оролцох, нийгмийн асуудлаар хэлэлцэх, дадлага хийх замаар ирээдүйн хариуцлагатай сонгогч болж төлөвшинэ.

Багийн нэр: Buddy

Шийдэл: Education платформ Оюутнуудын дотуур байрны хүрэлцээ муу, амьдрах орчин таагүй байдал болон их дээд сургуулиудын (МУИС, ШУТИС) төсвийн зарцуулалт ил тод бус байгаад оюутнууд нэгдсэн зохион байгуулалттайгаар шаардлага тавьж чадахгүй байна. Оюутнууд өөрсдийн асуудлаа дижитал хэлбэрээр мэдээлэх, цахим гарын үсэг цуглуулах, нөлөөллийн ажил өрнүүлэх боломжтой платформ. Энэ нь оюутны нийгмийн оролцоог идэвхжүүлж, боловсролын салбарын ил тод байдлыг сайжруулахад чиглэнэ.

Багийн нэр: Dandar

Шийдэл: henbe.mn вэбсайт Залуучууд улс төр, шийдвэр гаргах түвшний үйл явцад идэвхгүй ханддаг, улс төрчдийг сайн таньдаггүй ("Хэн бэ?"), мөн татвар төлөгчдийн мөнгө хэрхэн зарцуулагдаж буй талаарх "Шилэн данс"-ны мэдээлэл ойлгомжгүй, хүртээмжгүй байдаг. Улс төрчдийн намтар, хийсэн

ажил, гаргасан шийдвэр болон улсын төсвийн зарцуулалтыг ("Таны мөнгө хаачих вэ?") залууст ойлгомжтой, энгийн, сонирхолтой зурагт хуудас (visual cards) болон өгөгдөл хэлбэрээр харуулдаг вэбсайт. Энэ нь залуусын улс төрийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх зорилготой.

Багийн нэр: Dizzy

Шийдэл: Voice of Gobi AI платформ

Залуучуудын оролцоог шийдвэр гаргах түвшинд хүргэх засаг захиргаатай холбох гүүр болох, Өмнөговь аймгийн залуучуудын идэвх оролцооны дата эх үүсвэрийг бий болгох, дээрээс доошоо чиглэсэн асуудал шийдэх аргачлалыг өөрчилж дижитал оролцоогоор залуучууд шийдвэр гаргах албан тушаалтнуудад нээлттэйгээр дуу хоолойгоо илэрхийлэн, шийдлийг хүргүүлж нээлттэйгээр хэлэлцэх санал болгох зорилготой платформ. Уг платформ нь Өмнөговь аймгийн залуучуудад тулгамдаж буй бодлогын асуудал, оролцооны чанарын болоод тоон судалгааг гаргаж чиг хандлагыг тодорхойлно.

Багийн нэр: Visioneers

Шийдэл: GUURY платформ

Оюутанзалуусцагийн ажилхийх явцдаа хөдөлмөрийн мөлжлөгт өртөх, цалингүй ажиллах, гэрээ байгуулалгүйгээр эрхээ зөрчүүлэх тохиолдол их гардаг. Гэвч тэд хаана, хэнд хандахаа мэддэггүй эсвэл айж эмээснээс болж чимээгүй өнгөрдөг асуудлыг шийднэ. Ажил олгогч байгууллагуудын (жишээ нь: СУ, Номин гэх мэт) талаар сэтгэгдэл бичих, үнэлгээ өгөх, мөн хөдөлмөрийн зөрчлийн гомдлыг нэрээ нууцлан эсвэл нээлттэйгээр илгээх боломжтой "GuurY" дижитал гүүр-платформ юм. Энэхүү

платформ нь ирсэн гомдлыг багцлан холбогдох мэргэжлийн байгууллага, хяналтын газруудад дамжуулах үүрэг гүйцэтгэнэ.

Багийн нэр: Voice

Шийдэл: “Voice UB” сошиал платформууд (Facebook, YouTube, Instagram)

Нийслэлийн залуучууд хотын төсвийн зарцуулалт, томоохон бүтээн байгуулалт (жишээ нь: усан оргилуур, театр барих гэх мэт)-ын талаар мэдээлэлгүй, хяналт тавьж чаддаггүйгээс болж үргүй зардал гарсаар байна. Сошиал медиа сувгууд, подкаст, богино бичлэг (Reels) болон инфлюенсерүүдээр дамжуулан хотын асуудлыг "Storytelling" хэлбэрээр хүргэж, залуусын саналыг цуглуулна. Ингэснээр залуусын дуу хоолойг нэгтгэн, шийдвэр гаргагчдад "зөөлөн хүч"-ээр нөлөөлөх орон зайг бий болгоно.

Багийн нэр: MonEducation

Шийдэл: Боловсролын зээлийн сангийн хүртээмжийг нэмэгдүүлэх

Залуучуудын боловсролын тэгш хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, тэднийг зээлийн сангаар дамжуулан олон улсад суралцах, хөгжих боломж хязгаарлагдмал байна. Дэлгэрэнгүй: Өөрсдийн сургалтын төвийн үйл ажиллагаагаар дамжуулан залуучуудад мэдлэг, ур чадвар олгохын зэрэгцээ боловсролын зээлийн сангийн хүртээмжийг нэмэгдүүлэх, залуучуудад тэгш боломж олгоход зориулсан аппликэйшн хөгжүүлнэ.

МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ 2025

“Өөрчлөлтийн дуу хоолой” төсөл



Оюутан клубын үйл ажиллагааг дэмжих санхүүгийн тэтгэлэг олгох хөтөлбөр зарлагдаж, хөтөлбөрт хамрагдах клубүүд шалгарлаа

Монголын их, дээд сургуулиудын хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн сургуулийн баримт нягтлан шалгах, мэдээллийн суурь боловсролыг түгээн дэлгэрүүлэх оюутан клубын үйл ажиллагааг дэмжих санхүүгийн тэтгэлэг олгох хөтөлбөрийг 2025 оны 10-р сард зарласан. Үүний дагуу МУИС, МУБИС, РТМУС, Отгонтэнгэр их сургуулиудын клубүүд өргөдлөө ирүүлж 2026 оны 10-р сар хүртэл тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахаар болов. Энэхүү санхүүгийн тэтгэлгийн зорилго нь сонгогдсон их, дээд сургуулиудын баримт нягтлан шалгах болон Хэвлэл мэдээллийн суурь боловсролын (MIL) оюутны клубуудын үйл ажиллагааг өргөжүүлэх, тогтмолжуулахад дэмжлэг үзүүлнэ. Клубийн үйл ажиллагаа нь хэвлэл мэдээллийн суурь боловсрол (Media and Information Literacy, MIL), баримт нягтлан шалгах (Fact-Checking) гэсэн хоёр үндсэн чиглэлтэй байна.

МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн “NUM Journalists” клуб

Төслийн нэр: “Сэтгүүл зүйн нийгмийн хариуцлагыг оюутан үеэс төлөвшүүлэх”
Дэмжлэгийн дүн: 15000 евро
“Сэтгүүл зүйн нийгмийн хариуцлагыг оюутан үеэс төлөвшүүлэх” төслийн санаачилгыг хэрэгжүүлнэ. Тус клуб нь 2022 онд байгуулагдаж, МУИС-ийн оюутны албан ёсны клубийн бүртгэлд багтан, дотоод журмын дагуу идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Одоогоор сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны чиглэлээр суралцаж буй 30 орчим оюутан гишүүнтэй бөгөөд зөвхөн гишүүдийнхээ

ур чадварыг хөгжүүлэхээс гадна нийгмийн хариуцлагатай хэвлэл мэдээллийн орчныг бүрдүүлэхэд хувь нэмэр оруулахыг зорьдог.

Төслийн хүрээнд клубийн гишүүд баримт шалгах, ярилцлага авах, контент бүтээх ур чадвараа хөгжүүлж, цаашид Монголын ардчиллыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах чадвартай сэтгүүлчид болон төлөвших юм. Мөн олон нийтэд чиглэсэн контент, мэдээллийн үйл ажиллагаагаар дамжуулан хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролыг нэмэгдүүлж, хэвлэл мэдээллийг шүүн тунгаан хэрэглэдэг, хариуцлагатай хэрэглэгчдийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Ийнхүү төсөл нь оюутнуудыг нийгмийн хариуцлагатай иргэн, сэтгүүлч болгон төлөвшүүлэхийн зэрэгцээ их сургуулийн орчинд ил тод, мэдлэгт суурилсан мэдээллийн соёлыг бий болгохыг зорьж байна.

МУБИС-ийн Нийгэм, хүмүүнлэгийн ухааны сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн “VIBE” баримт шалгах клуб

Төслийн нэр: VIBE
Дэмжлэгийн дүн: 10000 евро
Улирал тутам тасралтгүй үйл ажиллагаа явуулан баримт шалгах арга зүйд суралцаж, мэдлэгээ бусдад түгээх зорилготой. Төслийн зорилго нь иргэдийн мэдээллийг бие даан үнэлэх, баримтыг шалгах чадварыг нэмэгдүүлж, хэвлэл мэдээллийг хариуцлагатай, шүүн тунгаан хэрэглэдэг уншигчдыг төлөвшүүлэхэд чиглэнэ. Үүний үр дүнд клубийн гишүүд болон сургалтад хамрагдсан оюутнууд

шүүмжлэлт сэтгэлгээгээ хөгжүүлж, их сургуулиудын хүрээнд хэвлэл мэдээллийн боловсрол, сэтгүүл зүйн ёс зүйн соёлыг төлөвшүүлэхэд бодит хувь нэмэр оруулах юм. Төслийн хүрээнд подкаст, влог, олон төрлийн арга хэмжээ зохион байгуулахын зэрэгцээ баримтад суурилсан, нотолгоотой мэдээлэл түгээх **VIBE.MN** вэбсайтыг ажиллуулж, эх сурвалж харьцуулах, хиймэл оюунд суурилсан шинжилгээ зэрэг орчин үеийн аргаар мэдээлэл нягтлах чадварыг иргэдэд эзэмшүүлнэ.

Отгонтэнгэр их сургуулийн “Баримт шалгагч” оюутны клуб

Төслийн нэр: MIND SHIELD
Дэмжлэгийн дүн: 10000 евро
“Баримт шалгагч” оюутны клуб залуусын хэвлэл мэдээлэл, мэдээллийн боловсролыг дээшлүүлэх зорилготой “MIND SHIELD” төслийг хэрэгжүүлж байна. Төсөл нь залуусын аналитик сэтгэлгээг хөгжүүлэх, мэдээллийн үнэн зөвийг үнэлэх, баримт шалгах суурь мэдлэг олгох, хариуцлагатай мэдээлэл түгээх дадлыг төлөвшүүлэхэд чиглэнэ. “Өөрчлөлтийн дуу хоолой” төслийн зорилготой нийцсэн уг санаачилга нь иргэний оролцоо, олон нийтийн мэдлэг, нийгмийн эв нэгдлийг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулах юм.

Мөн төслийн хүрээнд олж авсан мэдлэг, ур чадварыг зөвхөн сургалтаар хязгаарлахгүйгээр энгийн ойлгомжтой сургалт, контент боловсруулах ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Ингэснээр төслийн

үр нөлөө богино хугацаанд зогсохгүй, дараагийн үеийн залууст тасралтгүй шилжих боломж бүрдэх бөгөөд залуусыг мэдээллийг шүүн тунгааж хэрэглэдэг, нийгмийн хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах юм.

СУИС-ийн Кино, телевиз, медиа урлагийн сургуулийн дэргэдэх “Оюутан баримт шалгагч” клуб

Төслийн нэр: Оюутан баримт шалгагч клуб

Дэмжлэгийн дүн: 10000 евро
2025–2026 оны хичээлийн жилд баримт шалгах арга зүйд суурилсан мэдлэг, ур чадварыг оюутнуудад эзэмшүүлэхэд чиглэсэн цогц үйл ажиллагаа хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

Үүнд клубын үйл ажиллагааны орчныг бүрдүүлэх зорилгоор номын сангийн хэсгийг шинэчлэн тохижуулж, хурлын танхим, мэдээллийн самбар байгуулан ашиглах, сар тутам баримт шалгасан мэдээ, нийтлэл багтаасан сонин хэвлэн гаргах, мөн сошиал медиа болон цахим сувгаар үнэн зөв, баримтад суурилсан контент түгээх ажлууд багтсан. Эдгээр нь оюутнуудын мэдээлэл боловсруулах, шүүн тунгаах, эх сурвалж баталгаажуулах чадварыг бодитоор хөгжүүлэхэд чиглэнэ.

Мөн клубын гишүүдийн чадавхийг дээшлүүлэх зорилгоор 14 хоног тутам ментор урин сургалт, мастер класс зохион байгуулах,

дотоод баримт шалгах практик дасгалууд хийх, онлайн сорил, уралдаан, “Fact-check Challenge”, “Fake news detection challenge” зэрэг тэмцээнүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүний зэрэгцээ видео, нийтлэл, сургалтын контент үйлдвэрлэх, вебинар зохион байгуулах, жилийн эцэст шилдэг гишүүдийг шалгаруулах, тайлан гаргах замаар клубын үйл ажиллагааг тогтвортой, залгамж чанартай хөгжүүлэх зорилготой. Ийнхүү төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагаанууд нь оюутнуудыг баримтад суурилсан сэтгэлгээтэй, хариуцлагатай мэдээлэл бүтээгч, хэрэглэгч болгон төлөвшүүлэхэд чиглэсэн байна.

Клубүүдтэй үйл ажиллагааны явцыг танилцуулах уулзалтыг (Inception workshop) 2025 оны 11-р сарын 25-наас 27-нд хийлээ.



Төслийн үйл явцын тайлан, баримтжуулалтыг хэрхэн хийх талаар чиглүүлэх сургалтыг ДВА, ХМЗ-ийн төслийн

санхүүгийн багийнхан 2025 оны 12-р сарын 1-нд онлайн, офлайн хосломол хэлбэрээр зохион байгууллаа. Сургалтад

дөрвөн сургуулийн багш нар, оюутнууд, санхүүгийн мэргэжилтнүүд оролцов.



Камбожийн оюутан клубтэй туршлага хуваалцав

Хуурамч мэдээлэл, үзэн ядах үг хэллэг, ташаа мэдээ зэрэг нь хэвлэл мэдээллийн орчинд нь нөлөөлж байна. Ийм нөхцөлд хэрэглэгчид мэдээллийг ухамсартай, шүүмжлэлтэй, чадварлаг байдлаар хүлээн авах нь нэн чухал. Ялангуяа оюутан залуус хуурамч агуулга, төөрөгдүүлэх мэдээллийг ялган таних, мэдээллийн суурь боловсролтой байх нь

шүүмжлэлт сэтгэлгээ, бусад ур чадварын суурь болно. Мөн хөтөлбөрийн хүрээнд 2025 оны 12-р сарын 10-нд **Оюутны клубын туршлага хуваалцах онлайн уулзалт** зохион байгууллаа. Тус уулзалтаар Дойче Веллэ Академи (DWA)-аас Камбожийн “Media 101” клуб баримт нягтлан шалгах (fact checking), хэвлэл мэдээллийн суурь боловсролын (MIL - me-

dia literacy) талаар ажилладаг оюутны клубын туршлагаа хуваалцлаа. DWA-аас Камбожийн Бие даасан хэвлэл мэдээллийн төвтэй (Cambodian Center for Independent Media - CCIM) хамтран 2018 онд “Media 101” оюутан клубыг байгуулсан. Клубын үйл ажиллагаа нь их сургуулийн оюутнуудад чиглэсэн ба 20 орчим оюутан нэг бүлэг


МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ 2025

“Өөрчлөлтийн дуу хоолой” төсөл

болж гурван сарын сургалтад хамрагддаг. Залуучуудын дунд хэвлэл мэдээллийн хэрэгслийг аюулгүй, хариуцлагатай

ашиглах талаар мэдлэг олгох зорилгын хүрээнд уламжлалт болон сошиал медиа, худал мэдээлэл, түүнтэй тэмцэх,

дигитал аюулгүй байдал, гэрэл зураг, видео, подкаст гэх мэт сэдвүүдийг хамардаг аж.



Хэвлэл мэдээллийн ярилцлага, нийтлэлээс:

“Зууны мэдээ” сонины 2025 оны 9-р сарын 22-ны дугаар, “Д.Тэгшбаяр: Төрөөс платформ гаргаж, Иргэний нийгмийн байгууллагууд мэдээллээ оруулдаг байх нь зөв” ярилцлага

“ikon.mn” сайт, 2025 оны 10-р сарын 7, “Г.Гүнжидмаа: Зөвхөн сэтгүүлчид ч биш, бүгдээрээ ёс зүйн хариуцлагаа ухамсарлаж, AI эринийг зөв угтах ёстой” ярилцлага

“gogo.mn” сайт, 2025 оны 10-р сарын 9, “С.Бадрал: AI нөлөө нь чадварлаг, бүтээлч хүмүүст улам үнэлэгдэж, хүчтэй болох боломж олгож байна” ярилцлага

“gogo.mn” сайт, 2025 оны 10-р сарын 13, “Сэтгүүл зүйн ёс зүйн форум 2025: Ирээдүйд хиймэл оюун ухаан сэтгүүлчийг орлох уу?”

“Зууны мэдээ” сонины 2026 оны 1-р сарын 05-ны дугаар, “Ц.Сувданцэцэг: Нийгмийн хөгжилд иргэний нийгмийн байгууллагуудын дуу хоолой чухал үүрэгтэй” ярилцлага

“Иргэний нийгмийн байгууллагуудын эгэх хариуцлага, ил тод байдал, мэдээлэл харилцааны нөхцөл байдлыг тодорхойлох нь” судалгаатай танилцана уу: <https://www.mediacouncil.mn/a/704>

2026 ОНД ТӨЛӨВЛӨЖ БУЙ АЖЛУУД

- Иргэний нийгмийн өдрийг (1-р сарын 31) тохиолдуулан “Иргэний нийгмийн форум 2026” нэгдүгээр сарын 30-нд болно.
- “Хөгжлийн төлөөх эгэх хариуцлага: Иргэний нийгмийн санаачилга” иргэний нийгмийн байгууллагуудын үйл ажиллагаандаа баримтлах эгэх хариуцлагын зарчмуудын хэрэглэгдэхүүн (toolkit) бэлтгэж танилцуулна.
- Монголын Залуучуудын Эвслээс зохион байгуулж буй Иргэний нийгмийн өдрийг угтсан 7 хоногийн цуврал үйл ажиллагааг дэмжин ажиллана.
- Иргэний нийгмийн эрх зүйн орчинг сайжруулах чиглэлд Иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл, төрийн төлөөлөл бүхий гурвалсан бодлогын уулзалтыг үргэлжлүүлнэ.
- Эмзэг бүс нутагт залуучууд болон бусад эмзэг бүлгийн иргэдийн төрийн үйлчилгээний хүртээмжийн талаарх мэдээлэл цуглуулахыг дэмжих гуравдагч талд санхүүгийн дэмжлэг (FSTP) үзүүлэх хөтөлбөрийг зарлана.
- 2026 оны намар “Сэтгүүл зүйн ёс зүйн форум” болно.
- Иргэний нийгмийн байгууллагад зориулсан цахим орчинд мэдээлэл түгээхэд баримтлах ёс зүйн гарын авлагыг танилцуулна.

ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийг Европын Холбооны дэмжлэгтэйгээр Хэвлэл мэдээллийн зөвлөл, Дойче Велле Академи хамтран хэрэгжүүлж байна.

Санхүүжүүлэгч:
Европын Холбоо

Хэрэгжүүлэгч:
Монголын Хэвлэл Мэдээллийн Зөвлөл, ХБНГУ-ын Дойче Велле Академи

Хэрэгжих хугацаа:
2023-2026 он

Төслийн зорилго: Иргэний нийгмийн байгууллагуудын хариуцлагатай, ил тод, бие даасан байдлыг дэмжиж, иргэний нийгмийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх замаар сайн засаглал, нийгмийн эв нэгдэлд хувь нэмрээ оруулахад чиглэнэ.

ЗОРИЛТ 1.

ИНБ-уудын засаглал, цахим орчинд ажил хэргээ эрхлэх, үйл ажиллагаа явуулах чадавх сайжирч, “Хариуцлагатай иргэний нийгэм”-ийн удирдамжийг бий болгосон байна.

ЗОРИЛТ 2.

Төр, иргэний нийгмийн байгууллагууд, хэвлэл мэдээллийнхэн иргэдийн оролцоог дэмжих эрх зүйн болон бодлогын таатай орчныг бүрдүүлэх талаар харилцан ойлголцлоо нэмэгдүүлнэ.

ЗОРИЛТ 3.

ИНБ, хэвлэл мэдээлэл хамтран бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх, нөлөөллийн үйл

ажиллагаа явуулахдаа залуучууд, нийгмийн бусад бүлгийг идэвхтэй оролцуулах цахим харилцааны шинэ хэлбэрийг дэмжинэ.

Зорилтот бүлгүүд

- ИНБ: Иргэний нийгмийн салбарын хот, хөдөөгийн нийт 500 ажилтан – үүний 50% нь залуучуудтай ажилладаг

- Залуучууд: 16–35 насны 800 залуу – 50% нь эмэгтэй.

- Хэвлэл мэдээлэл: Хот, хөдөөгийн хэвлэл мэдээллийн байгууллагад ажилладаг 500 ажилтан (сэтгүүлч, редактор гэх мэт) – 50% нь эмэгтэй.

- Төрийн төлөөлөгчид: Хот, хөдөөгийн 100 улс төрийн болон төрийн албан хаагч – иргэний нийгмийн асуудалд сонирхолтой, өөрчлөлт авчрах чадамжтай бүлэг.

Хэвлэл Мэдээллийн Зөвлөл (ХМЗ) нь сэтгүүлч, ажил олгогч, салбарын эвсэл холбоод, мэргэжлийн байгууллагуудын санаачилга, амжилттай хамтын ажиллагааны үр дүнд анхлан байгуулагдаж, үйл ажиллагаагаа хэрэгжүүлээд даруй 10 дахь жилдээ орж буй НҮТББ билээ. Энэ хугацаанд Хэвлэл Мэдээллийн Зөвлөл нь хэвлэл мэдээллийн байгууллагуудын хариуцлагыг сайжруулах, сэтгүүл зүйн ёс зүй болон мэргэжлийн стандартыг хөгжүүлэх зэрэг үйл ажиллагааны үндсэн чиглэлийнхээ хүрээнд олон нийтээс ирүүлсэн 600 гаруй гомдлыг хүлээн авч, хэлэлцэн шийдвэрлээд байна. Улмаар хэвлэл мэдээллийн салбарт ажиллагсад өөрсдийн бий болгосон ёс зүйн зарчмаа дагаж

мөрддөг, салбарын өөрийн зохицуулалтын механизмыг амжилттай бий болгоод байна.

Монгол Улсад хэвлэл мэдээллийн салбарын өөрийн зохицуулалтыг хөгжүүлэн бэхжүүлж буй туршлага болон хэвлэл мэдээлэл - төр - иргэний нийгмийн хөгжлийн төлөөх хамтын түншлэл, харилцаа холбоог бэхжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанууд нь хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн эгэх хариуцлагыг хөндөх “Өөрчлөлтийн дуу хоолой: Иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлага, ил тод байдал, олон нийтийн ойлголтын төлөө хүчээ нэгтгэх нь” төслийг хэрэгжүүлэх үндэс суурь болсон юм.

Гурван жилийн хугацаатай хэрэгжих уг төслийг Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр Хэвлэл Мэдээллийн Зөвлөл, ХБНГУ-ын Дойче Велле Академи хамтран хэрэгжүүлэх бөгөөд иргэний нийгмийн байгууллагуудын хариуцлагатай, ил тод, бие даасан байдлыг дэмжиж, иргэний нийгмийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх замаар сайн засаглал, нийгмийн эв нэгдэлд хувь нэмрээ оруулах юм.

Энэхүү төслийн үйл ажиллагааны танилцуулга товхимлыг төсөл хэрэгжүүлэгч Хэвлэл Мэдээллийн Зөвлөл эмхэтгэн боловсруулсан ба Европын Холбооны санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлэв. Энэхүү төслийн үйл ажиллагааны танилцуулга товхимол нь Европын Холбооны албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй болно.